



VIII/2021

Тархаасан: 2021 оны 9 дүгээр сарын 13



Хураасан хүнсний ногоо өмнөх оны мөн үеэс 14.3 хувиар өслөө


Ургац хураалтын явцын мэдээгээр улсын хэмжээнд 2021 оны 9 дүгээр сарын 1-ний байдлаар 69.2 мянган тонн хадлан хадаж, 14.4 мянган тонн хүнсний ногоо, 6.8 мянган тонн төмс хурааж, 243.0 тонн гар тэжээл бэлтгэсэн байна.

Өмнөх оны мөн үетэй харьцуулахад хүнсний ногоо 14.3 хувь буюу 1.8 мянган тонноор, гар тэжээл 29.1 хувь буюу 54.8 тонноор өссөн бол, харин бэлтгэсэн хадлан 7.1 хувь буюу 5.3 мянган тонноор, хураасан төмс 15.6 хувь буюу 1.2 мянган тонноор тус тус буурсан байна. Бэлтгэсэн хадлан буурсанд 2021 оны 8 дугаар сард хур тунадасын нийлбэр 2268.5 мм-т хүрч олон жилийн дунджаас 33.9 хувиар илүү байсан нь нөлөөлсөн байна.

Хураасан төмс өмнөх оны мөн үеэс Дундговь, Баян-Өлгий, Баянхонгор, Говьсүмбэр, Булган, Орхон, Сүхбаатар, Завхан, Сэлэнгэ, Төв аймгуудад 2.2 тонноос 1.7 мянган тонноор буюу 5.7-95.3 хувиар буурч, харин Улаанбаатар хот болон бусад аймагт 0.5-987.8 тонн буюу 0.4 хувиас 19.5 дахин өссөн байна.

Хураасан хүнсний ногоо өмнөх оны мөн үеэс Төв, Архангай, Говьсүмбэр, Орхон, Сүхбаатар, Завхан, Булган, Өмнөговь, Сэлэнгэ аймгуудад 4.5-977.1 тонн буюу 0.8-91.5 хувиар буурч, харин Улаанбаатар хот болон бусад аймагт 1.4 тонноос 1.7 мянган тонноор буюу 2.7 хувиас 32.5 дахин өссөн байна.

ЗУРАГ 1. ХУРААСАН ТӨМС, ХҮНСНИЙ НОГОО, мянган тонн, жил бүрийн 9 дүгээр сарын 1-ний байдлаар



Ойлголт, тодорхойлолт:

Тариалсан талбай гэж хөдөө аж ахуйн ургамал тариалсан талбайг хэлэх бөгөөд тухайн жилд үр суулгасан газрын нийт хэмжээгээр тодорхойлно.

Нийт хураасан ургац нь тариалсан бүх талбайгаас хураан авсан үр тариа, төмс, хүнсний ногоо, жимс жимсгэнэ, малын тэжээл, техник, тосны ургамал зэрэг таримал ургамлын хэмжээгээр тодорхойлогдоно.

Га-гийн ургац гэж талбайн нэгжээс /1 га-гаас/ авах газар тариалангийн бүтээгдэхүүний /ургацын/ хэмжээ юм. Га-гийн ургацыг тодорхойлохдоо нэг төрлийн ургамал тариалсан талбайгаас хураан авсан бүх ургацыг тариалсан талбайн хэмжээнд нь харьцуулна.



Эх үүсвэр: Ургац хураалт, хадлан тэжээл, бэлтгэлийн мэдээ (ХАА-8)

Ангилал, код: Бүтээгдэхүүн үйлчилгээний нэгдсэн ангилал

Мэдээлэл авах холбоос:

<http://www.nso.mn/>

<http://www.1212.mn/>

Дараагийн мэдээ тархаах хуваарь: 2021 оны 10 дугаар сарын 15

Эдийн засгийн статистикийн газрын
дарга А.Дэмбэрэл
Утас : (976-11)-329271

Эдийн засгийн статистикийн газрын
статистикч Х.Энхжавхлан
Утас : (976-51)-261565



/StatisticMGL



information@nso.mn



1900-1212